



2014

АНДЕРРАЙТИНГИЙН ГАРЫН АВЛАГА

ДААТГАЛЫН ТӨРӨЛ: “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ”

Д.Жаргал /Монгол Даатгал ХХК/

С.Золбоо /Практикал Даатгал ХХК/

Ч.Бат-Эрдэнэ /Бодь Даатгал ХХК/

С.Нарантунгалаг /Соёмбо Даатгал ХХК/

Ц.Мандах-Эрдэнэ /МИД төсөл/

Э.Ууганбаяр /Ард Даатгал ХХК/

Б.Мөнхдэлгэр /Хаан Даатгал ХХК/

Б.Баярхүү /Санхүүгийн Зохицуулах хороо/

Б.Жавхланцогт /Монголын даатгагчдчын холбоо/

АГУУЛГА

Хэсэг 1	ЕРӨНХИЙ ЗАРЧИМ	ху-3
Хэсэг 2	НЭР ТОМЪЁО	ху-4
Хэсэг 3	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ	ху-5
Хэсэг 4	ҮНЭЛГЭЭ	ху-7
Хэсэг 5	ЭРСДЭЛ	ху-8
Хэсэг 6	ХАСАЛТ	ху-9
Хэсэг 7	БУСАД НӨХЦЛҮҮД	ху-11
Хэсэг 8	ХУРААМЖИЙН ТООЦООЛОЛ	ху-14
Хэсэг 9	НӨӨЦИЙН САНГИЙН ТООЦООЛОЛ	ху-19
Хэсэг 10	ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦЛҮҮД	ху-21
Хэсэг 11	АНДЕРРАЙТИНГИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	ху-31
Хэсэг 12	ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ АКТУУД	ху-21
Хэсэг 13	СТАТИСТИК МЭДЭЭ	ху-35

ХЭСЭГ 1 ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Энэхүү гарын авлага нь Даатгагч, даатгуулагчийн хооронд байгуулах тээврийн хэрэгслийн даатгалын гэрээтэй холбоотой харилцааг бүрэн зохицуулах зорилготой, хүлээн авч болохуйц эрсдэлийг үр ашигтайгаар, өрсөлдөхүйц үндэслэлтэй үнээр, тархаан байршуулж, сөрөг сонголтоос хамгаалсан, андеррайтингийн хяналт, шалгалтын зарчмуудыг үндэслэн даатгалын хамгаалалтыг бий болгох үндэс суурь болно.

Монгол Улсын тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд өнгөрсөн онд нийт импортын бүтээгдэхүүний 40 хувийг автомашин эзэлсэн байгаа нь тээврийн хэрэгслийн хэрэгцээ хэр их байгааг харуулж байгаа юм.

Нийт автомашины 50-60 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод ашиглагдаж байна.

	2012	2013	ӨСӨЛТ БУУРАЛТ
Суудлын	354383	433382	↑ 22.2%
Ачааны	106711	151530	↑ 42.0%
Автобус	9285	5992	↓ -35.4%
Механизм	6654	8468	↑ 24.3%
Тусгай	18416	18726	↑ 1.6%
Мотоцикл	24339	25571	↑ 5.0%
Чиргүүл	19105	20385	↑ 6.6%
Бусад	15528	11010	↓ -29.0%
БҮГД	554577	675064	↑ 21.7%

Монгол Улсын Даатгалын зах зээлийн хувьд Тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нь уламжлалт хэлбэрийн бүтээгдэхүүн бөгөөд өнгөрсөн оны СЗХорооноос гаргасан мэдээгээр нийт хураамжийн орлогын 17,3 хувийг, нөхөн төлбөрийн хувьд нийт нөхөн төлбөрийн 28,1 хувийг эзэлж байгаагаар мэдээлэгдсэн байна.

Дээрхи тоон мэдээллээс харахад тээврийн хэрэгслийн даатгал нь эрсдэл өндөртэй бүтээгдэхүүнд тооцогддог бөгөөд бид хамралт нэмэгдүүлэх, эрсдэлээ зөв үнэлэн хураамжийн хувийг бодитой тооцоолох зорилготойгоор энэхүү гарын авлагыг боловсрууллаа.

Нийт ашиглагдаж буй автомашины ихэнх хувь нь хуучин автомашин байдаг онцлогтой зах зээл учраас андеррайтинггаа түүнд тохирсон хэлбэрээр хийв.

Даатгалын үндсэн 7 зарчим

1. **(Indemnity) Нөхөн төлбөрийн зарчим**
Даатгалын гэрээний дагуу даатгуулагчид тохиролцсон эрсдэл, аюулын улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх.
2. **(Insurable Interest) Даатгалын сонирхолтой байх зарчим**
Даатгуулагч өөрийн гэр байшиндаа л даатгалын сонирхолтой байхаас хөршийнхөө байшинд бус гэсэн зарчим юм. Даатгуулагч даатгалын хамаарах асуудлаар хууль эрх зүйн зөв харилцаатай байх. Энэ нь гэнэтийн ослын даатгалын хувьд хууль ёсны өв залгамжлал хүртэх эрх бүхий этгээдийг нэрлэж өгөх. Даатгуулагчийн гэр бүлийн гишүүдийг ирээдүйд бий болох санхүүгийн эрсдлээс хамгаалах үүднээс даатгуулах.
3. **(Proximate cause) Шууд шалтгааны зарчим**
Даатгуулагчийн даатгалын зүйлд эрсдэл учирсан анхдагч шалтгааныг илрүүлэх. Тухайн эрсдэл нь шууд буюу анхдагч эрсдэл байх ёстой.
4. **(Utmost good faith) Туйлын үнэнч шударга байх зарчим**
Даатгалын гэрээ байгуулагч талууд нь туйлын үнэнч шударга байх тухай бөгөөд гэрээнд оролцогч талуудын аль алинд ноогддог үүрэг юм. Даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулах эсвэл хүсэлт гаргах өргөдөл бөглөхдөө даатгуулах зүйлийнхээ талаар бүрэн гүйцэд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн даатгагч эрсдлийг хүлээн авах эсэх, ямар хэмжээний хамгаалалт үзүүлэх эсэхээ шийддэг. Даатгагчийн хувьд даатгуулагчдад үйл ажиллагааны болон санхүүгийн хувьд ил тод нээлттэй, тунгалаг байх үүрэгтэй.
5. **(Contribution) Контрибуци зарчим**
Даатгалын компаниудын хооронд гарч ирдэг зарчим юм. Даатгуулагч өөрийн эд хөрөнгөө хэд хэдэн даатгуулагчид зэрэг даатгуулах, нөхөн төлбөрийг тэдгээр даатгагчаас авах хандлагатай байдаг учраас даатгалын компаниуд хоорондоо мэдээлэл, тооцооны харилцаатай байх гэсэн зарчим юм.
6. **(Subrogation) Суброгаци зарчим**
Даатгуулагчийн эд хөрөнгө амь насанд эрсдэл учирч түүнд нь гуравдагч этгээд буруутай бол даатгуулагчийн хохирлыг түргэн шуурхай барагдуулах ба гаргасан нөхөн төлбөр ба түүнтэй холбогдон гарах зардлын нийлбэрээр буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх зарчим юм.
7. **(Arbitration) Маргаан шийдвэрлэх зарчим**
Даатгал нь мөнгөтэй холбоотой харилцаа учраас маргаан үл ойлголцол гарах нь элбэг. Даатгуулагч, даатгагчийн хооронд маргааныг шийдвэрлэх нэг арга нь маргааныг шүүхээр бус дундын гуравдагч этгээдийн шийдвэрийг хүлээн авч шийдвэрлэгэдэг хуулийн арга техник юм.

1. “Даатгал” - аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эд хөрөнгийн болон хуульд харшлаагч эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг болзошгүй эрсдэлээс даатгах вйл ажиллагааг;
2. "Даатгагч" - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль тогтоомжийн дагуу даатгалын вйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан ашгийн төлөө компанийг;
3. "даатгуулагч" гэдэгт хууль болон гэрээний үндсэн дээр даатгалын зүйлээ даатгагчид даатгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
4. “Даатгалын зүйл” эд хөрөнгө болон хуульд харшлаагч эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг;
5. "даатгалын эрсдэл" гэдэгт даатгалд хамрагдсан зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
6. “Даатгалд хамрагдахгүй нөхцөл” -
7. "даатгалын хугацаа" гэдэгт даатгалын гэрээний хвчин төгөлдөр байх хугацааг;
8. “Даатгалын тохиолдол” - даатгалын зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
9. “Даатгалын үнэлгээ” – даатгалын зүйлийн зах зээлийн үнийг үндэслэн Даатгагч Даатгуулагч нар харилцан тохиорлоцсон үнийг;
10. “Зах зээлийн үнэ” - даатгалын зүйлтэй ижил төрлийн шинж чанартай, ашиглалтын зорилго, хөрөнгийн элэгдлийн хувьд ойролцоо автотээврийн хэрэгслийг тухайн үед даатгалын зүйл оршин байгаа нутаг дэвсгэрт худалдах, худалдан авч болох үнийг;
11. "даатгалын хураамж" - даатгуулагч өөрийн тээврийн хэрэглээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
12. “Даатгалын хураамжийн хөнгөлөлт” –
13. “Нөхөн төлбөр” – гэдэгт даатгалын тохиолдлоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгийг;
14. "Даатгалын баталгаа" гэдэгт даатгуулагчийн тээврийн хэрэгслийг даатгасныг баталж, даатгагчаас олгох даатгалын нөхцөлийг тусгасан албан ёсны баримт бичгийг;
15. “Даатгуулагчийн хариуцах хэсэг” -
16. “Бүрэн сүйрэл” - тухайн тээврийн хэрэгсэлд хийх засварын зардал даатгалын үнэлгээтэй тэнцэх, эсвэл илүү гарсан тохиолдлыг;
17. “Хэсэгчилсэн хохирол” - бүрэн сүйрлээс бусад тохиолдолд даатгагч тээврийн хэрэгсэлд засвар хийх, эд ангиудыг солих эсвэл засвар үйлчилгээний зардлыг нөхөн төлөхийг сонгосон тохиолдлыг тус тус хэлнэ.
18. “Нэмэлт тоног төхөөрөмж, хэрэгслүүд” – үйлдвэрээс тавигдаагүй боловч Даатгуулагчийн Даатгагчид мэдэгдсэнээр даатгалын баталгаанд жагсаагдсан нэмэлт хэрэгсэл, тоноглол, эд анги, тоног төхөөрөмжийг;
19. "даатгалын нөөцийн сан" - даатгуулагчид учирч болзошгүй хохирлыг нөхөх зорилгоор даатгагч нь даатгалын хураамжийн цэвэр орлогоос тооцож нөхөх мөнгөн хөрөнгийг;
20. "давхар даатгал" гэдэгт даатгагч нь даатгуулагчийн өмнө хвлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгах хэлбэрийг.

ХЭСЭГ 3 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ

Даатгуулагчийн төрөл	Ангилал	Тээврийн хэргслийн зориулалт	ТАЙЛБАР
ХУУЛИЙН ЭТГЭЭД	А	Хувийн	Албан хэрэгцээнд ашиглах/жи: хоол хүргэлт/+
		Түрээс	Түрээсийн зориулалтаар түрээслүүлэх /жи: жуулчдад түрээслүүлэх/
	В	Такси үйлчилгээ	Зориулалтын хөлсний тэргээр иргэдэд үйлчлэх
		Хувийн	Албан хэрэгцээнд ашиглах /хуулийн этгээдийн албаны зориулалтаар/
		Жолооны сургалт	Тээврийн хэрэгслийг жолооны сургалтаар ашиглах
		Түрээс	Түрээсийн зориулалтаар ашиглах /жи: жуулчдад түрээслүүлэх/
	С	Хувийн	Албан хэрэгцээнд ашиглах /нүүлгэлт, уул уурхай, барилгын зориулалтаар/
		Түрээс	Түрээсийн зориулалтаар ашиглах /жи: иргэн, хуулийн этгээдэд хөлсөөр түрээслэх/
	D	Нийтийн тээвэр	Тогтсон маршрутын дагуу хот дотор нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх
		Хот хоорондын тээвэр	Хот хооронд зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх
		Ажилчдын автобус	Ажилчид, оюутан, сурагчдыг гэрээс ажил сургуульд нь, сургууль ажлаас гэрт нь хүргэж өгөх үйлчилгээ үзүүлэх
		Түрээс	Иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээнд хөлсөөр үйлчлэх /жи: хонхны баяр, амралт зугаалга/
	M	Хувийн	Албан хэрэгцээнд ашиглах /уул уурхай, барилгын зориулалтаар ашиглах/
		Түрээс	Түрээсийн зориулалтаар ашиглах /жи: иргэн, хуулийн этгээдэд хөлсөөр түрээслэх
ХУВЬ ХҮН	A	Хувийн	Ойр зуурын хэрэгцээнд ашиглах, жагсаал цугларалт, аялал хийх
	B	Хувийн	Ойр зуурын хэрэгцээ, аялал
		Түрээс	Хувийн тээврийн хэрэгслээр хөлсний тэрэгний үйлчилгээ үзүүлэх
	C	Хувийн	Ойр зуурын хэрэгцээ, нүүх
		Түрээс	Хөлсөөр үйлчилгээ үзүүлэх
	D	Хувийн	Ойр зуурын хэрэгцээ, аялал
		Түрээс	Хөлсөөр үйлчилгээ үзүүлэх
	M	Түрээс	Хөлсөөр үйлчилгээ үзүүлэх

ХЭСЭГ.4 ҮНЭЛГЭЭ

- 4.1 “Даатгалын үнэлгээ” – даатгалын зүйлийн зах зээлийн үнийг үндэслэн Даатгагч Даатгуулагч нар харилцан тохиорлцсон үнийг хэлнэ.
 - 4.1.2 “Зах зээлийн үнэ” - даатгалын зүйлтэй ижил төрлийн шинж чанартай, ашиглалтын зорилго, хөрөнгийн элэгдлийн хувьд ойролцоо автотээврийн хэрэгслийг тухайн үед даатгалын зүйл оршин байгаа нутаг дэвсгэрт худалдах, худалдан авч болох үнэ;
 - 4.1.3 “Татваргүй үнэлгээ” гэж элчин сайдын яам болон олон улсын байгууллагын тээврийн хэрэгслийн татвар тооцогдоогүй үнэлгээ.
- 4.2 Даатгалын үнэлгээ хийх аргачлал
 - 4.2.1 Даатгагч, даатгуулагч талууд даатгалын үнэлгээгээ харилцан тохиролцоно.
 - 4.2.2 Даатгалын үнэлгээг төгрөг, (валютаар) үнэлж даатгалын гэрээ байгуулж болно.
 - 4.2.3 Даатгалын үнэлгээг гадаад валютаар тооцож хийсэн нөхцөлд тухайн үеийн Монголбанкны ханшаар шилжүүлж даатгалын гэрээнд тусгана.
- 4.3 Эд хөрөнгийн даатгалын үнэлгээ
 - 4.3.1 Эд хөрөнгийг даатгахдаа өөрийн өртөг, зах зээлийн үнийг баримтлан даатгагч, даатгуулагч нар харилцан тохирч даатгалын үнэлгээг тогтооно.
 - 4.3.2 Даатгуулж буй эд хөрөнгийг үзэж, даатгалын үнэлгээний хэмжээг даатгагч газар дээр нь шалгаж энэ журмын 1.1-д зааснаар тогтоож болно.
 - 4.3.3 Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ нь тухайн хөрөнгийн өөрийн өртөг эсвэл зах зээлийн үнээс илүүгүй байна.
 - 4.3.4 Тухайн эд хөрөнгийг өөрийн өртөг, зах зээлийн үнээс илүү өндөр үнээр үнэлж даатгасан нөхцөлд даатгалын үнэлгээний илүү хэсгийг даатгагч хүчингүйд тооцно.
 - 4.3.5 Даатгагч байгууллага, иргэдийн эд хөрөнгийг үндэслэлгүйгээр хэт багаар үнэлж даатгахыг хориглоно.
 - 4.3.6 Эд хөрөнгөө зах зээлийн үнэ болон өөрийн өртгөөс өндрөөр үнэлж даатгахыг даатгуулагч нарт хориглоно.

ХЭСЭГ 5. ЭРСДЭЛ*Basic cover - Үндсэн эрсдэл*

№	ДААТГАЛЫН ЭРСДЭЛҮҮД:
1	Зам тээврийн осол
2	Байгалийн эрсдэл
3	Барилга, сантехникийн эрсдэл: Зогсоол талбай гаражид зогсож байх үеийн дулаан сантехникийн осол, барилгын нуралт.

Additional cover- нэмэлт хамгаалалт

№	ДААТГАЛЫН ЭРСДЭЛҮҮД:
1	Галын эрсдэл: Гал түймэр, тэсрэлт, дэлбэрэлт
2	Дугуйн эрсдэл:Замын хөдөлгөөнд оролцож байх үед хурц ирмэгтэй зүйлд зүсэгдэх, урагдах байдлаар дугуйнд учирсан хохирол.
3	Хулгайн эрсдэл:Тээврийн хэрэгслийг бүхэлд нь хулгайд алдах
4	Жижиг эд ангийн хулгайн эрсдэл: Толь болон автомашины доторх эд ангид тооцогдох зүйл хулгайд алдагдах.
5	Шилний хохирол:Зам тээврийн ослоос үл хамаарах шалтгаанаар үүссэн салхи, хаалганы шилэнд учирсан гэмтэл
6	Гуравдагч этгээдээс учруулах хохирол:Тээврийн хэрэгсэл зогсоол талбай, гаражид байх үед гуравдагч этгээдийн буруутай үйлдлээс учирсан эвдрэл гэмтэл.
7	Өөрийн санаандгүй үйлдлээс гарах эрсдэл:Зогсоол талбай , гаражид ухрах, зогсох байрлуулах үйлдэл хийх үедээ даатгуулагч өөрийн санаандгүй үйлдлээс тээврийн хэрэгсэлдээ учруулсан хохирол.

Special cover- тусгай хамгаалалт

№	ДААТГАЛЫН ЭРСДЭЛҮҮД:
1	Баталгаат хугацааны хамгаалалт
2	Элэгдлийн зардлын хамгаалалт
3	Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хамгаалалт
4	Тээврийн хэрэгслийн заалтаас хамаарах хамгаалалт
5	Жолоочийн онцлогоос хамаарах хамгаалалт
6	Жолооч болон зорчигчийн гэнэтийн ослын хамгаалалт

1. Санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчныг бүрдүүлсэн Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 2.3 а-д заасан нөхцөлүүд.
2. Даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.
3. Даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд, түүний эрх ашгийг хамгаалагч гуравдагч этгээдийн санаатай үйлдлээс учирсан хохирол.
4. Тээврийн хэрэгслийг согтуугаар эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоодсон, хурд хэтрүүлсэн нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, гэмт хэргийн зорилгоор хууль бусаар ашиглах үед үүссэн хохирол.
5. Ослын талаар даатгагч болон Замын Цагдаагийн байгууллагад хүндэтгэх шалтгаантайгаас бусад тохиолдолд зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэж ослын шалтгааныг тогтоолгоогүй, эсвэл ослын шалтгааныг тогтоох боломжгүй болсон.
6. Гэрээнд заагдаагүй эрсдэлийн улмаас үүссэн хохирол.
7. Автомашины эвдрэл, цахилгааны гэмтэл, нэмэлт тоног төхөөрөмжийн гэмтэл, автомашинд хийсэн засварын ажлаас шалтгаалан гарсан гал болон эвдрэл зэргээр автомашинаас өөрөөс нь үүссэн галын хохирол.
8. Тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, тухайн ангилалын тээврийн хэрэслийг жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан үедээ автомашин жолоодсон, эрүүл мэндийн хувьд жолоо барих шаардлага хангахгүй этгээдээр жолоо бариулсан үед учирсан хохирол.
9. Тээврийн хэрэгслийг жолооны сургалтын зориулалтаар ашиглах, ан ав хөөх, уралдаан тэмцээнд оролцуулах, тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хязгаараас хэтрүүлэх, тээврийн хэрэгслийн хүч, туулах чадварыг турших, баталгаат бус замаар зорчих, гол ус гатлах зэргээс учирсан хохирол.
10. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн бол тэр хэмжээгээр.
11. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйн улмаас автомашинд гарсан ердийн эвдрэл, автомашины ашиглалтаас хамаарсан элэгдэл хорогдол, үйлдвэрийн гологдлоос учирсан хохирол.
12. Зам тээврийн ослоос үл хамаарах шалтгаанаар тээврийн хэрэгслээр хад чулуу, хатуу биет зүйл мөргөх зэргээр даатгалын тохиолдол бий болох орчин нөхцлийг даатгуулагч өөрийн буруугаас бүрдүүлснээс учирсан хохирол.
13. Монгол улсын Замын Хөдөлгөөний Дүрэмд заагдсан дор дурьдсан тохиолдолд үүссэн гэмтэл, хохирол:
 - a. Тээврийн хэрэгслийг ашиглахыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хориглосон шийдвэр гаргасан, техникийн гэмтэлтэй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оруулснаас үүссэн хохирол.
 - b. Зорчигч болон ачаа тээш тээвэрлэх журмыг зөрчсөнөөс үүссэн хохирол.
14. Даатгалын тохиолдолтой холбоогүй механик засвар үйлчилгээ, машины нөхцөл байдлыг сайжруулах болон тэдгээрийн үр дагавраас үүссэн хохирол.

15. Ослоос бусад шалтгаанаар электрон компьютер, компьютерын программ хангамжинд учирсан хохирол, мөн тэдгээрээс үүссэн аливаа хохирол
16. Хулгай, дээрмийн улмаас даатгалтай машин дотор байсан хувийн эд зүйл, нэмэлт тоноглол, өөр даатгалд хамрагдсан эд хөрөнгө болон задгай бүхээгтэй машин доторх эд зүйл алдагдсанаас үүссэн хохирол
17. Даатгуулагч гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн хохирол
18. Гэрээнд тусгайлан заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах хохирол.
19. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл үүссэн.

ХЭСЭГ 7 БУСАД НӨХЦЛҮҮД

Даатгалын хугацаа

1. Тээврийн хэрэгслийн даатгалын хугацаа 1 жил буюу 12 сар байна.
 - а. Хэрэв 12 сараас доош хугацаагаар даатгах тохиолдол үүсвэл даатгалын хураамжийг “Даатгалын хураамжийн тооцоолол” хэсгийн дагуу тооцно.
 - б. 12 сараас дээш хугацаагаар даатгах бол гэрээг жил бүрээр сунгахаар тооцоолон хураамжийг ашиглах хугацааг жилээр тооцно

Үзүүлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
Эхний улиралд төлөгдөх хураамжийн хувь	-	-	0.47%	0.156%	0.156%	0.156%	0.156%	0.156%	0.156%	0.156%	0.156%	0.156%
Тухайн сард төлөх хураамжийн хувь	-	-	0.47%	0.176%	0.165%	0.162%	0.161%	0.160%	0.159%	0.159%	0.158%	0.158%

Даатгалын гэрээний цуцлалт

1. Даатгалын гэрээний цуцлалт дараах 2 шалтгаантай байдаг.
 - а. Даатгагчийн саналаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахад даатгалтай байх хугацаанд ямар нэгэн нөхөн төлбөр олгоогүй тохиолдолд гэрээний цуцлалт хийж үлдсэн хугацаанд ноогдох хураамжийг дараах томъёог ашиглан даатгагчид буцаан олгоно.

$$\left\{ \frac{\text{Төлсөн даатгалын хураамж}}{\text{даатгалын хугацаа}} * \text{даатгалтай байсан хугацаа} \right\} - \text{уг гэрээнд хамаарах зуучлалын хөлс,}$$

- б. Даатгуулагчийн саналаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахад даатгалтай байх хугацаанд нөхөн төлбөр олгоогүй бол үлдсэн хугацаанд ноогдох даатгалын хураамжаас даатгалтай холбогдсон зардлыг хассан дүнгээр даатгуулагчид буцаан олгох ба дараах томъёог ашиглана.

$$\left\{ \frac{\text{Төлсөн даатгалын хураамж}}{\text{даатгалын хугацаа}} * \text{даатгалтай байсан хугацаа} \right\} - \text{даатгалын баталгааны үнэ - зуучлалын хөлс,}$$

Давхар даатгал:

1. Даатгагч буюу давхар даатгуулагч анхны даатгуулагчийн өмнө хүлээсэн гэрээний хариуцлагаа хураамж төлсний үндсэн дээр давхар даатгагчид шилжүүлэх гэрээний хэлбэр юм.
2. Даатгаж буй тээврийн хэрэгслийн даатгалын үнэлгээ компанийн нөөцийн сан, багцын давхар даатгалын үнэлгээний нийлбэрээс давсан тохиолдолд давхар даатгалын газарт хандана.

Асуулгын хуудас:

1. Даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө даатгуулагчаас асуулгын хуудсыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулан авах ба асуулгын хуудасны мэдээллээр эрдэл тооцоолох мэдээллийн үндэс болно.

Хам даатгал:

1. 2 ба түүнээс дээш даатгагч 1 даатгалын гэрээний нөхцлөөр өөрсдийн хүлээх хариуцлагын дагуу даатгалын хураамж, нөхөн төлбөр болон гэрээний дагуу ногдол ашиг, шимтгэл, хураамжийн татвар гэх мэт бусад зардлыг хариуцсан хувь хэмжээгээр хүлээх даатгалын гэрээний хэлбэр юм.
2. Хам даатгалын гэрээний Ерөнхий даатгагч нь даатгалын гэрээтэй холбоотой зохицуулалтуудыг хийхээр гэрээг байгуулна.

Хугацааны дунд нэмэлт хамгаалалт авах

$$\text{Нэмэлт хамгаалалтын жилийн хураамж} - \left\{ \frac{\text{нэмэлт хамгаалалтын жилийн хураамж}}{\text{нийт даатгалын хугацаа}} * \text{хамгаалалттай хугацаа} \right\}$$

Хураамж төлөх хэлбэр

1. Даатгалын хураамжийг даатгалын гэрээ байгуулсан даруйд бэлнээр бол тухайн өдөртөө, дансаар шилжүүлэхдээ ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.
2. Даатгалын гэрээнд даатгалын хураамжийг хэсэгчлэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулсан тохиолдолд хураамжийг хуваарийн дагуу төлнө.
3. Гэрээ байгуулсны эхний төлбөр нь нийт хураамжийг 25 хувь байх ба үлдэх хэсгийг дурын хугацаагаар төлөх боломжтой.

Даатгалын үнэлгээнд өөрчлөлт орвол

$$\text{нэмэлт үнэлгээний жилийн хураамж} - \frac{(\text{нэмэлт үнэлгээний жилийн хураамж}}{\text{нийт даатгалын хугацаа}} \text{ хамгаалалтгүй} * \text{хугацаа}$$

1. Даатгуулагч тээврийн хэрэгслээ худалдсан, бэлэглэсэн зэрэг бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийн даатгалыг өөр тээврийн хэрэгслийн даатгалд шилжүүлэх тохиолдлыг хэлнэ.
2. Шилжүүлэн даатгуулах гэж буй тээврийн хэрэгслийн үнэлгээ өмнөх тээврийн хэрэгслийн үнэлгээнээс их тохиолдолд “Даатгалын үнэлгээнд өөрчлөлт орвол” хэсгийн дагуу тооцно.
3. Харин Шилжүүлэн даатгуулах гэж буй тээврийн хэрэгслийн үнэлгээ өмнөх тээврийн хэрэгслийн үнэлгээнээс бага тохиолдолд шууд шилжүүлнэ.
4. Тухайн тээврийн хэрэгсэл даатгалтай байх хугацаандаа нөхөн төлбөр авсан бол даатгалын гэрээний зүйлийн шилжүүлэлт хийгдэхгүй.

Өөрийн хүлээх хариуцлагын хэмжээний өөрчлөлт

Өөрийн хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх нь даатгалын хураамжийг бууруулах үндэслэл болно. Өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг бууруулах нь даатгалын хураамжийг нэмэгдүүлэх үндэслэл болно.

Өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ	20%	15%	10%	5%
Үндсэн хураамжийн хувь	1.87%	2.5%	3.1%	3.7%
Нийт хураамжийн хувь	1.87%	2.52%	3.09%	3.74%

Нэмэлт тоноглол

Үйлдвэрийн суурь иж бүрдэл дээр нэмсэн эсвэл өөрчилж суурилуулсан гоёлын болон хүч нэмэгдүүлсэн, тав тухыг сайжруулж хангасан аливаа тоног төхөөрөмжийг нэмэлт тоноглол гэнэ. Нэмэлт тоног төхөөрөмжийн үнийн дүнгээр өссөн үнэлгээгээгээр даатгалын хураамжийг тооцно. Даатгалын гэрээн нэмэлт тоноглол тус бүрээр нь даатгалын үнэлгээг гарган бичнэ.

Даатгалын гэрээг хаяж үрэгдүүлсэн тохиолдол

Хаясан, гэсэн тохиолдолд тус даатгалын гэрээг хүчингүйд тооцуулан сонинд зарлуулсан баримтыг үндэслэн даатгалын баталгааны үнийг төлүүлэн нөхөн олгоно. Дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд хуучин баталгааг хурааж, даатгалын баталгааны үнийг төлүүлэн нөхөн олгоно.

Даатгалын гэрээний зүйлд өөрчлөлт орсон тохиолдол

Тээврийн хэрэгсэлийн өнгө, арлын дугаар, улсын дугаар зэрэгт өөрчлөлт орсон тохиолдолд тухайн гэрээн дээр нь өөрчлөлт оруулан өөрчлөлт тэмдэглэгээ хийн огноогоо тавьж, даатгагч гарын үсэг зурж тэмдгээ тавьсанаар гэрээний зүйлд өөрчлөлт орсон тохиолдол хүчин төгөлдөр болно .

Жолооч болон зорчигчийн гэнэтийн ослын тусгай эрсдэл: Даатгуулагч энэ эрсдэлээс даатгуулахыг хүссэн үед гэнэтийн ослын даатгалын нөхцлийг санал болгоно.

Moral hazard /зан төлөвийн аюул/

Хэт хайнга үйлдэлийн улмаас нөхөн төлбөрийн тохиолдол их гарч байгаа үед дараах аргачлалаар даатгалын тохиолдол гарах давтамжийг бууруулах арга хэмжээ авч болно. Үүнд:

- a. Даатгуулагчийн хариуцах хэсгийн хэмжээг нэмэгдүүлэх, тохиолдлын хязгаар тогтоох
- b. Даатгалд хамрагдахгүй нөхцөлд хэт хайхрамжгүй үйлдийн тухай заалт нэмж оруулах

1. RATING & RISK GROUPS / Хураамж тооцоолох, эрсдэлийн бүлгүүд/

Guide rate / Хураамжийг тооцоолох үндсэн аргачлал

Даатгалын хураамжийн хэмжээг ямар даатгалын бүтээгдэхүүн зэргээс хамаарч олон аргачлал, загваруудаар тооцоолдог. Тооцоологч актуарч, андеррайтингийн шийдвэрээс хамаарч өөр өөр байх боломжтой. Даатгалын хураамж нь тодорхой бүтэцтэй байдаг бөгөөд бүрдүүлэгч элементүүд нь даатгагчийн хүлээсэн бүх үүрэг ба эдгээр үүргүүдийг санхүүжүүлэхэд хүрэлцэхүйц байх ёстой.

- Даатгалын гэрээний хугацаанд үүсэх хохирлыг нөхөн төлөх.
- Даатгалын нөөц үүсгэх.
- Даатгалын компанийн үйл ажиллагааны зардлыг нөхөх.
- Тодорхой хэмжээний ашиг гаргах зэрэгт хүрэлцэхүйц байх ёстой.

Даатгалын хураамжийн тооцоолол дахь хамгийн чухал асуудал нь рисков цэвэр хураамжийн хэмжээ байдаг бөгөөд энэ тооцоолол нь үүсч болох хохирлыг бүрэн хэмжээнд төлөх өндөр магадлалтайгаар хийгдэх ёстой.

	Хураамжийн бүрдүүлэгч	Зориулалт
Нийт хураамж	Рискийн цэвэр хураамж	Даатгалын тохиолдол үүссэн үед хохирлыг нөхөх
	Нэмэгдэл хураамж	Даатгалын нөөцийг бүрдүүлэх
	Компанийн зардлын нэмэгдэл	Үйл ажиллагааны зардлууд { Тогтмол, хувьсах }
	Ашгийн нэмэгдэл	Олох ашиг

Даатгалын хураамжийг тооцоолох арга

Даатгалын хураамж тооцох 2 арга байдаг.

- Нөхөн төлбөрийн харьцаан дээр тооцох, хохирол гарах магадлал дээр тооцох
- Нийт гарсан ослыг дундаж гарсан хохирлын хэмжээгээр тооцох

Даатгалын хураамжийн гол тооцоолол нь цэвэр хураамжийн орлого нөхөн олговрын зардлаас давах баталгаа нь 100 хувиас бага ч түүнд дөхсөн түвшинтэй байхаар тооцох асуудал юм.Өөрөөр хэлбэл дараах тэнцэл бишээр бичиж болно.

$$P\{\text{нөхөн олговор} < \text{цэвэр хураамж}\} \geq \gamma \text{ Да}$$

Энд γ - нь даатгуулагчийн аюулгүйн баталгааны түвшин.85%-99.9% хооронд байдаг.

Хураамжийн тооцооллын үндсэн санаа нь даатгалын хураамж нь нөхөн төлбөр болон учирч болзошгүй нөхөн төлбөрийн тэнцвэрт үндэслэн хийх юм. Энэ нь богино хугацаа,болоон урт хугацааны нөхөн төлбөрөө хураамжийн хувьдаа шингээж тооцлоо.

Хохирлын түвшний арга

Энэ аргаар хураамжийг тооцоолохдоо хэрэглэж байгаа хураамжийн тарифыг тохируулагч коэффициентээр үржүүлэх бөгөөд тохируулагч коэффициент нь бодит хохирлын түвшин, зорилтот хохирлын түвшин 2-ын харьцаагаар тодорхойлогдоно.

Эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөлөл

Тухайн тээврийн хэрэгслийн ангилал, моторын хүчин чадал, ашиглалтын хугацаа, зориулалт, урьд өмнө даатгалын тохиолдол гарч байсан эсэх зэрэг хүчин зүйлүүдийг илүү нарийн тооцох зэрэг нь учирч болзошгүй эрсдэлүүдийг тооцоолж, багасгах нэг арга зам болно.

- Тээврийн хэрэгслийн үнэ цэнэ
- Тээврийн хэрэгслийн төрөл, ангилал
- Тээврийн хэрэгслийн нөхцөл байдал / хуучин, шинэ /
- Тээврийн хэрэгслийн эргэн тойронд буюу доторх учирч болзошгүй аюул
- Тээврийн хэрэгслийн насжилт
- Тээврийн хэрэгслийн ашиглах нөхцөл
- Аюулгүй байдлын арга хэмжээ
- Тээврийн хэрэгслийн ашиглах байршил
- Тээврийн хэрэгслийн одоогийн хийгдсэн даатгал
- Тээврийн хэрэгслийн нөхөн төлбөрийн түүх

Тээврийн хэрэгслийн ангилал бүрээрх үндсэн хураамжийн боломжит хувь

Даатгуулагчийн төрөл	Ангилал	Тээврийн хэрэгслийн зориулалт	Боломжит хураамжийн хувь
ХУУЛИЙН ЭТГЭЭД	A	Хувийн	0,8 %
		Түрээс	1,0 %
	B	Такси үйлчилгээ	1,5 %
		Хувийн	1,0 %
		Жолооны сургалт	2,0 %
		Түрээс	2,0%
	C	Хувийн	1,2 %
		Түрээс	1,6 %
	D	Нийтийн тээвэр	2,6 %
		Хот хоорондын тээвэр	2,0 %
		Ажилчдын автобус	1,6 %
		Түрээс	2,2 %
M	Хувийн	1,7 %	
	Түрээс	2,1 %	
ХУВЬ ХҮН	A	Хувийн	1,0 %
		Түрээс	1,6 %
	B	Хувийн	1,6 %
		Түрээс	1,8 %
	C	Хувийн	1,3 %
		Түрээс	1,6 %
	D	Хувийн	1,4 %
		Түрээс	1,7 %
	M	Түрээс	1,7 %

Basic premium-Үндсэн хураамж / Зах зээлийн байдлаар /

Risk / Эрсдэл	Net Premium	Нэмэлт хураамжийн хувь			Gross Premium
		Reserve	Cost	Profit	
Зам тээврийн хөдөлгөөний үеийн эрсдэл	0,5 %	Компанийн санхүү, эдийн засгийн тооцооллоор нэмэгдэнэ.			1.87%
Сантехникийн усны эрсдэл					
Байгалийн эрсдэл					

- Нэмэлт хураамжийн хувь хэмжээг даатгалын компани санхүү, эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн хамрагдалт зэргээс хамааран тооцдог тул өөрчлөгдөх боломжтой.

a. Additional premium and loading-Нэмэлт хураамж

Risk / Эрсдэл	Risk Premium / Цэвэр хураамж	Нэмэлт хураамжийн хувь			Gross Premium / Нийт хураамж
		Reserve / Нөөц	Cost / Зардлын хувь	Profit / Ашгийн хувь	
Гуравдагч этгээдийн санаатай буюу санамсаргүй эрсдэл	0,6 %	Компанийн санхүү, эдийн засгийн тооцооллоор нэмэгдэнэ.			0,5 – 2,0 %
Жолоо шилжүүлэх эрсдэл	0,5 %				
Их биеийн хулгай дээрмийн эрсдэл	0,9 %				
Жижиг эд ангиудын хулгайн эрсдэл	1,1 %				
Бусад галын эрсдэл	0,8 %				
Тээвэрлэлтийн үеийн эрсдэл	0,4 %				

- Нэмэлт эрсдэлийн цэвэр хураамжийг олон жилийн статистик болон даатгагчийн статистик мэдээлэлд тулгуурлан тооцоолох шаардлагатай.

b. Minimum premium- Байж болох хамгийн доод хураамж

Risk Premium / Цэвэр хураамж / Эрсдэлийн хураамж	Нэмэлт хураамжийн хувь			Gross Premium / Нийт хураамж
	Reserve / Нөөц	Cost / Зардлын хувь	Profit / Ашгийн хувь	
0.33%	Компанийн санхүү, эдийн засгийн тооцооллоор нэмэгдэнэ.			0.87%

- Тухайн тээврийн хэрэгсэл дээрх хамгийн бага хураамжийн хэмжээг актуарч, андеррайтер нь тодорхойлно.
- Цэвэр хураамжийн хэмжээг олон жилийн дундаж статистик мэдээлэлд тулгуурладаг, харин нэмэлт хураамжийн хувийг даатгагч бүр өөрийн санхүү, эдийн засгийн үзүүлэлт, боломжит тооцдог тул өөрчилөх боломжтой. Улирал, жилийн борлуулалтын төлөвлөгөө, зардал, хийгдэх боломжит даатгалын гэрээний тоо зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдээс хамаарч хураамжийн байж болох хамгийн доод хэмжээг тооцоолно.

ХЭСЭГ 10 НӨӨЦИЙН САНГИЙН ТООЦООЛОЛ

Reserve fund calculation / Нөөц сангийн тооцоолол

Орлогод тооцсон хураамж

Улирал	Нийт хураамжийн орлого =Цэвэр хураамжийн орлого	Орлогод тооцсон хураамжийн дүн
2015.I	939,183,280	117,397,910
2015.II	626,122,186	313,061,093
2015.III	626,122,186	469,591,640
2015.IV	939,183,280	665,254,823
-	-	665,254,823
-	-	469,591,640
-	-	313,061,093
-	-	117,397,910
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
-	-	-
	3,130,610,932	3,130,610,932

Даатгагчийн санхүү, актуарын үзүүлэлт

Санхүүгийн үзүүлэлт	2015.I	2015.II	2015.III	2015.IV
Нийт хийгдэх гэрээний тоо	2,503	1,669	1,669	2,503
I гэрээний хураамжийн дүн	375,157	375,157	375,157	375,157
Нийт хураамжийн орлого	939,183,279.74	626,122,186.50	626,122,186.50	939,183,279.74
Үйл ажиллагааны зардал	328,714,147.91	219,142,765.27	219,142,765.27	328,714,147.91
Учирч болзошгүй нөхөн төлбөр/ нөөц сан	125,488,878.03	83,659,252.02	83,659,252.02	125,488,878.03
Орлогод тооцсон хураамжийн дүн	117,397,910	313,061,093	469,591,640	665,254,823
Зардлын харьцаа	280%	70%	47%	49%
Хохирол нөхөлтийн харьцаа	107%	27%	18%	19%
Хосолсон харьцаа	387%	97%	64%	68%

- Зардлын харьцаа, хохирлын харьцаа, хосолсон харьцааг тооцоолж, зохистой хэмжээнд нь байхаар тооцож, ажиллах.

Хураамж тооцох арга

Ашигтай ажиллахын тулд даатгалын компаниуд нь доорх зардлыг хураамжиндаа багтаах шаардлагатай:

Нийт хураамжийн хэмжээ = цэвэр хураамж+үйл ажиллагааны зардал+зуучлагчийн шимтгэл/маркетингийн зардал+тооцооллын алдааны засвар зардал+бусад зардал+ашиг

*** Цэвэр хураамж нь нийт хураамжийн нэг хэсэг бөгөөд бусад зардал болон ашигийг оруулаагүй ирээдүйд учирч болох нөхөн төлбөрийн хэмжээг хэлдэг.**

Даатгалын компаний андеррайтерууд цэвэр хураамжийг доорх томъёоллоор тооцоолно:

Цэвэр хураамж= ирээдүйд учрах дундаж нөхөн төлбөрийн зардал*ирээдүйд учрах нөхөн төлбөрийн давтамж

Цэвэр хураамжийг тооцох 2 арга байдаг:

1. **Турилагад үндэслэсэн арга** – тухайн бүтээгдэхүүнд сүүлийн хэдэн жилийн хангалттай мэдээлэл байгаа бол, андеррайтерууд учирсан дундаж нөхөн төлбөрийн зардалыг тооцоолж болно.

Ирээдүйд учрах дундаж нөхөн төлбөрийн зардал=Нийт нөхөн төлбөрийн хэмжээ/Нийт нөхөн төлбөрийн тоо

2. **Үнэлгээний арга** – эд хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл ойролцоо төрлийн эд хөрөнгийн зах зээлийн үнэн дээр тулгуурлан андеррайтерууд учирч болох дундаж нөхөн төлбөр болон хохирлыг тодорхойлж болно. Даатгагч энэхүү аргаар эд хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл даатгалын үнэлгээг цэвэр хураамжийг тооцохдоо ашиглаж болно.

Ирээдүйд учрах нөхөн төлбөрийн давтамжийг тооцоолохдоо бүтээгдэхүүний эрсдлийн хамаарлыг авч үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, андеррайтерууд нь зөвхөн тэр эрсдлийн туршлага дээр үндэслэн нэгж эрсдлийн хураамжийг тооцож чадахгүй учир андеррайтерууд нь эрсдлийн шинж чанар болон хүчин зүйлүүдийг ашиглах хэрэгтэй. Ингэснээр, эрсдлийг тооцохдоо хураамжийн ангилалуудыг ашиглан тооцоолох бөгөөд энэ нь ижил төстэй боломжит хохирол учирч болох эрсдлүүдийг бүлэглэх мөн бүлэг доторх ялгаатай боломжит хохирлуудыг илэрхийлэх өөр өөр хураамжийн тооцоог гараар бодож өгч нэмэж тооцно. Эдгээр эрсдлийг хамааралтай болон ялгаатай талаар нь 4 шалгуураар бүлэглэж болж байна.

- **Статистикийн мэдээнд тулгуурласан шалгуур** – андеррайтерууд нь боломжит хураамж тооцох сонголтуудын үнэн бодит байдлыг бататгахад нь доорх статистикт тулгуурласан шалгуурыг ашиглана:
 - Статистикийн мэдээний ач холбогдол
 - Ижил төстэй байдал
 - Бодитой байдал
- **Operational Criteria** – For rating variable to be considered practical, it should be: үйл ажиллагааны шалгуур -
 - Зорилготой чиглэсэн
 - Үйл ажиллагаа явуулахад үнэтэй биш
 - Хянаж болохуйц
- **Нийгмийн шалгуур** – тодорхой нэг эрсдлийг хураамж тооцох өөр нэгэн нөхцөл болгон ашиглахдаа олон нийтийн хэрхэн хүлээж авч байгааг тодорхойлохдоо доорх зүйлсийг шалгуур болгоно:
 - Худалдан авах чадамж
 - Шалтгаант холбоо
 - Удирдах боломж
 - Хувийн шалтгаан
- **Хуулийн шалгуур** – андеррайтерууд юуг хэрэглэж болох болохгүй гэдгийг мэдэж байхын тулд хууль болон журмуудыг сайн мэдэж байх шаардлагатай.

Андеррайтингийн харьцаа

1. *Хохирлын харьцаа = нийт хохирол / орлогод тооцсон хураамж*
2. *Андеррайтингийн хохирлын харьцаа = учирсан нөхөн төлбөр / орлогод тооцсон хураамж*
3. *Хосолсон харьцаа = (Нийт хохирол + зардал) / орлогод тооцсон хураамж*
4. *Андеррайтингийн зардал = Андеррайтингийн нийт зардал / даатгалын хураамж*
5. *Удирдлагын зардлын харьцаа = Удирдлагын зардал / орлогод тооцсон хураамж*
6. *Нөөцийн харьцаа = Сунгасан гэрээний тоо / боломжит сунгах гэрээний тоо*

Хураамж тооцох шинжилгээнд шаардлагатай статистик мэдээлэл – нөхөн төлбөрийн мэдээлэл

- Хохирлын огноо
- Мэдээлсэн огноо
- Нөхөн төлбөр төлсөн хэмжээ болон огноо
- Шийдвэрлэгдээгүй нөхөн төлбөрийн хэмжээний тооцоолол
- Эрсдлийн төрөл (нөхөн төлбөр хүсч буй зүйл заалт)
- Нөхөн төлбөрийн төрөл
- Нөхөн төлбөрт нөлөөлж буй хураамж тооцох хүчин зүйлс

Бүх нөхөн төлбөрийн мэдээ нь хураамж тооцох хүчин зүйлүүдийн дагуу хадгалагдсан байх ёстой.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү даатгалын гэрээгээр Даатгуулагч нь тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулан хураамж төлөх, даатгагч нь даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгуулагчид гэрээгээр тохирсон нөхөн төлбөрийг олгох үүрэг хүлээв.
- 1.2 Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрднө.
- 1.3 Энэхүү даатгалын гэрээний үйлчлэх хүрээ нь Монгол улсын нутаг дэвсгэр байна.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. “Даатгал” - аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эд хөрөнгийн болон хуульд харшлаагчид эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг болзошгүй эрсдэлээс даатгах вйл ажиллагааг;
- 2.2. "Даатгагч" - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль тогтоомжийн дагуу даатгалын вйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан ашигийн төлөө компанийг;
- 2.3. "даатгуулагч" гэдэгт хууль болон гэрээний үндсэн дээр даатгалын звйлээ даатгагчид даатгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
- 2.4. “Даатгалд хамрагдахгүй нөхцөл” -
- 2.5. “Зах зээлийн үнэ” - тухайн тээврийн хэрэгслийн загвар, модел, үйлдвэрлэсэн он, гүйсэн км-ийн заалт, ерөнхий байдал зэрэгтэй ойролцоо хөрөнгө худалдаж авч болох үнийг;
- 2.6. “даатгалын зүйл” гэдэгт даатгуулагчийн өмчлөл эзэмшилд тээврийн хэрэгсэл болон жолоочийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, зорчигчийн амь нас, эрүүл мэндийг;
- 2.7. “тээврийн хэрэгслийн үнэлгээ” гэдэгт даатгуулж байгаа тээврийн хэрэгслийн мөнгөн илэрхийллийн хэмжээг;
- 2.8. “хариуцлагын үнэлгээ” гэдэгт жолоочийн даатгалын тухай хуулийн 9-р зүйлд заасан хариуцлагын үнэлгээг;
- 2.9. “гэрээт баталгаа” гэдэгт даатгалын зүйл, үнэлгээ, хураамж, хугацааг тусгасан даатгалын гэрээ хийсэн тухайг нотолж даатгуулагчид олгосон баримт бичгийг;
- 2.10. “даатгалын эрсдэл” гэдэгт даатгалын зүйлд хохирол учруулж болох нөхцөл, орчныг;
- 2.11. “даатгалын тохиолдол” гэдэгт даатгалын звйлд даатгалын эрсдлийн улмаас учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
- 2.12. “даатгалын хураамж” гэдэгт даатгуулагч даатгалын звйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 2.13. “даатгалын нөхөн төлбөр” гэдэгт даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;
- 2.14. “бүрэн сүйрэл” гэдэгт тээврийн хэрэгсэл, нөхөн сэргээгдэх, засварлагдах боломжгүй буюу нөхөн сэргээгдэх зардал нь даатгалын үнэлгээнээс хэтэрсэн байх нөхцөл байдлыг;
- 2.15. “нөхөн сэргээх үнэлгээ” гэдэгт тээврийн хэрэгсэл нөхөн сэргээгдэх, засварлагдахад гарах шууд зардал буюу сэлбэгийн үнэ, эд ангийг засах зардал, будаг туслах материалын зардал, ажлын хөлсний зах зээлийн үнэлгээг;
- 2.16. “өөрийн хүлээх хариуцлага” гэдэгт даатгалын тохиолдлоос үүссэн хохиролд даатгагчийн олгох нөхөн төлбөрөөс хасагдах хэмжээ буюу даатгуулагчийн хариуцах мөнгөн төлбөрийн хэмжээг;
- 2.17. “элэгдэл” гэдэгт тээврийн хэрэгсэл нь хэвийн ашиглалтын явцад зөвхөн хугацаанаас хамааран хорогдсон өртгийг;
- 2.18. “хамтран даатгуулагч” гэдэгт даатгуулагчийн гэр бүлийн баталгаатай эхнэр/нөхөр, жолоо барих эрхийн үнэмлэхтэй 18 нас хүрсэн хүүхэд, даатгалын гэрээнд нэр нь бичигдсэн этгээд, хөдөлмөрийн гэрээгээр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа жолоочийг;
- 2.19. “зам тээврийн осол” гэдэгт тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцон зөвхөн явж байх үедээ зам тээврийн осолд орохыг ойлгоно, энд зогсоол талбай, гаражид ухрах, зогсох, байрлуулах үйлдэл хийхдээ багана, шон хашлага мөргөх, батлагдаагүй замаар явж автомашиныхаа хүч туулах чадварыг үзсэн, гол ус гатлах зэргээр автомашиндаа учруулсан хохирол хамаарахгүй.

- 2.20. “хүндэтгэх шалтгаан” гэдэгт байгалийн гамшигт нэрвэгдсэн, хорио цээр тогтоосон бүсэд тусгаарлагдсан, хүндээр өвдөж гэмтсэн, бусдад яаралтай тусламж үзүүлсэн, хөдөө хээр газар даатгалын тохиолдол болсон гэх мэтийг тус тус ойлгоно.
- 2.21. “Хураамжийн тохиргоо” гэж даатгуулагчийн даатгагдсан тээврийн хэрэгсэл өөрчлөгдөх, нэмж тээврийн хэрэгсэл даатгагдах, даатгагдсан тээврийн хэрэгсэл хасагдах гэх зэрэг өөрчлөлт орсон тохиолдолд даатгалын хураамжийн тооцооллыг хийж жилийн эцэст тооцоо нийлнэ.

ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

3.1. Дор дурдсан тээврийн хэрэгслийг даатгалын зүйлд тооцно.

3.1.1. Хавсралт, даатгалын баталгаанд заасан тээврийн хэрэгсэл.

3.1.2. Даатгуулагчийн хүсэлт гаргаснаар хоёр тал харилцан тохиролцож тээврийн хэрэгсэлд анх үйлдвэрээс суурилуулсан иж бүрдэлд ороогүй, шинээр суурилуулсан нэмэгдэл тоног төхөөрөмж болох аудио болон видео тоног төхөөрөмж, гэрлэн болон дохиоллын төхөөрөмж, автомашин халаагч тоног төхөөрөмжийг нэмэлтээр даатгуулсан бол тэдгээр нь даатгалын зүйл болно.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

4.1 Үндсэн эрсдэл

- 4.1.1 Замын хөдөлгөөнд оролцох үеийн бүх төрлийн эрсдэл
- 4.1.2 Зориулалтын зогсоол талбай дээр байрлах үед учирсан бүх эрсдэл
- 4.1.3 Байгалийн эрсдэл (Хөлдөлтөөс бусад даатгагдаж болох байгалийн бүх эрсдэлүүд)
- 4.1.4 Сантехникийн усны эрсдэл
- 4.1.5 Гал, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт

4.2 Нэмэлт эрсдэл

- 4.2.1 Жолоо шилжүүлэх
- 4.2.2 Бүх төрлийн гэнэтийн осол, гадны нөлөөлөл, цохилтууд гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл / шил хагалах, мөргөөд зугтах
- 4.2.3 Тээвэрлэлтийн үеийн эрсдэл
- 4.2.4 Их биеийн хулгай дээрмийн эрсдэл
- 4.2.5 Жижиг эд ангиудын хулгайн эрсдэл
- 4.2.6 Нэмэлт зардал
- 4.2.7 Дугуйн эрсдэл
- 4.2.8 Барилга, сантехникийн эрсдэл

4.3 Тусгай эрсдэл

- 4.3.1 Баталгаат хугацааны хамгаалалт
- 4.3.2 Элэгдлийн зардлын хамгаалалт
- 4.3.3 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хамгаалалт
- 4.3.4 Тээврийн хэрэгслийн заалтаас хамаарах хамгаалалт
- 4.3.5 Жолоочийн онцлогоос хамаарах хамгаалалт
- 4.3.6 Жолооч болон зорчигчийн гэнэтийн ослын хамгаалалт

ТАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

- 5.1. Тээврийн хэрэгслийн үнэлгээ: _____ төгрөг
5.2. Даатгалын хураамж: _____ төгрөг

ЗУРГАА. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ, ТООЦОХ НӨХЦӨЛ

- 6.1. Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, даатгалын гэрээгээр зохицуулагдана.
- 6.2. Даатгагч нь даатгуулагчид учирсан хохирлын шалтгаан, хэмжээг тогтоосон дүгнэлт, үнэлгээ болон дор дурьдсан баримт материалыг үндэслэн даатгалын гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр олгоно.
- 6.2.1. Даатгуулагчийн даатгалын нөхөн төлбөр хүссэн өргөдөл, албан бичиг.
- 6.2.2. Даатгалын гэрээ, гэрээт баталгааны эх хувь.
- 6.2.3. Даатгалын тохиолдлын газар дээр ажилласан тухай протокол, дүгнэлт.
- 6.2.4. Даатгуулагч буруутай эсэхийг магадлах зорилгоор ослын шалтгааныг тогтоосон зам тээврийн ослын акт /акт үйлдэгдээгүй тохиолдолд тодорхойлолт.
- 6.2.5. Учирсан хохиролд үнэлгээ хийсэн үнэлгээчний дүгнэлт.
- 6.2.6. Эвдрэл гэмтэлд засвар хийсэн засварын газрын баримт.
- 6.2.7. Эвдрэл, гэмтлийн байдлыг харуулсан фото зураг.
- 6.2.8. Шаардлагатай тохиолдолд гал, үнэлгээ зэрэг мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагын дүгнэлт, тодорхойлолт.
- 6.2.9. Зам тээврийн осол хэрэг нь Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагад шалгагдаж, хянагдаж байгаа тохиолдолд тэдгээр байгууллагын шийдвэр.
- 6.3. Даатгалтай автомашин бүрэн сүйрсэн тохиолдолд даатгалын үнэлгээнээс түүний элэгдэл хорогдол, даатгуулагчийн сонгосон ангилалаас хамааран өөрийн хүлээх хариуцлагыг хасаж хохирлыг 100 хувиар нөхөн төлбөр олгоно. Энэ тохиолдолд даатгалын зүйлийн үлдэгдлийг даатгагчийн өмчид шилжүүлнэ.
- 6.4. Даатгалтай автомашинд учирсан эвдрэл гэмтлийн хохиролд нөхөн сэргээх үнэлгээнээс түүний элэгдлийг тооцон, гэрээнд заасан даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг хасаж тооцон нөхөн төлбөр олгоно.
- 6.5. Хохирлын шалтгаан нь даатгуулагчийн буруугаас болсон тохиолдолд Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д зааснаар даатгуулагч илт буруутайгаас бусад тохиолдолд даатгуулагчийн сонгосон багцаас хамааран олгохоор тооцсон нөхөн төлбөрийн дүнгийн 0-20 хувь хүртэл хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.5.1. Хохирлын шалтгаан нь урсгал сөрөх, эргэх үйлдэл хийхийг хориглосон газар буцаж эргэх, зөвшөөрөгдөөгүй гэрлэн дохиогоор хөдөлгөөн хийх, ослын дохио болон болон зогсолтын тэмдэг хэрэглээгүй, түр зогсохыг хориглосон газар зогсох зэрэг илт буруутай, мөн зам тээврийн ослын талаар даатгагчид нэн даруй мэдэгдэх даатгуулагчийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөхөн төлбөрийн дүнгийн 20 хувь хүртэл хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.6. Тээврийн хэрэгслийн шилний хохирол нь замын хөдлөгөөний аюулгүй байдалд нөлөөлөхгүй тохиолдолд засварын зардлын хэмжээгээр нөхөн төлбөр олгох ба хэрвээ уг хохирол нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхөөр болсон тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг 100 хувь хүртэл нөхөж олгоно.

- 6.7. Жижиг эд ангийн хулгайн даатгалын тохиолдолд тээврийн хэрэгслийн толь, гэрэл, дугуй, хөгжим гэх мэт машины үндсэн эд зүйлд учирсан хохиролд энэхүү гэрээний 6.4-д зааснаар нөхөн төлбөр олгоно.
- 6.8. Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртөг баримтаар нотлогдсон бол нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид олгох ба нөхөн төлбөрийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.
- 6.9. Даатгалын зүйлийн даатгалын үнэлгээ түүний зах зээлийн бодит үнээс бага байвал нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээний зах зээлийн үнэд эзлэх хувиар хувь тэнцүүлэн олгоно.
- 6.10. Даатгалын хугацаанд олгогдох нөхөн төлбөрийн нийт хэмжээ гэрээт баталгаанд заасан даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- 6.11. Даатгагч даатгалын тохиолдлын газар дээр очиж ажиллан протокол дүгнэлт бичих боломжгүй алс газар, хөдөө орон нутагт гарсан тохиолдлын хувьд энэ журмын 6.2 дахь заалтад зааснаас гадна дараах баримт, материалыг даатгуулагч бүрдүүлэх шаардлагатай.
 - 6.11.1. Орон нутгийн цагдаагийн байгууллагын акт, тодорхойлолт
 - 6.11.2. Осол болон эвдрэл, гэмтлийн 4-өөс доошгүй хувь фото зураг
 - 6.11.3. Тээврийн хэрэгслийн жолооч согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг нотолсон эрх бүхий байгууллагын бичиг баримт
 - 6.11.4. Хоёроос доошгүй гэрчийн тодорхойлолт мэдүүлэг.
- 6.12. Нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр төлөх эсвэл сэлбэх, засварлах, солих зэргийг Даатгуулагчийн саналыг авч даатгагч өөрийн сонголтоор шийдвэрлэнэ.
- 6.13. Тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийг даатгагч нөхөн төлбөр хүссэн өргөдөл, материалыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан олгоно.
- 6.14. Даатгуулагчаас хүлээн авсан өргөдөл материал нь гэрээнд заасан нотлох баримтын шаардлага хангахгүй дутуу, эргэлзээтэй байх эсвэл тухайн асуудлаар эрх бүхий байгууллагаар дүгнэлт тодорхойлолт гаргуулахаар даатгагч хүсэлт гаргасан, эсвэл эрх бүхий байгууллага хянаж шалгаж шийдвэр гаргаагүй байгаа тохиолдолд энэ журмын 6.13-д заасан хугацаа үйлчлэхгүй.

ДОЛОО. ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУГАЦАА, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ

- 7.1. Энэхүү даатгалын гэрээ **20__оны __дугаар сарын __-ны өдрөөс эхлэн 20__ оны __дугаар сарын __-ны өдрийг дуустал** хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 7.2. Дараах тохиолдлуудад даатгалын гэрээ дуусгавар болно.
 - 7.3.1. Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
 - 7.3.2. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
 - 7.3.3. Даатгагч даатгуулагч талууд тохиролцож гэрээг цуцалсан;
 - 7.3.4. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзсэн;
 - 7.3.5. Даатгагч даатгуулагчийн аль нэг нь дампуурсан, татан буугдсан;
 - 7.3.6. Даатгуулсан тээврийн хэрэгслийг шүүхийн шийдвэрээр хураасан.
- 7.3. Дараах тохиолдолуудад даатгалын гэрээг цуцлана.
 - 7.4.1. Хоёр талын аль нэг нь гэрээг цуцлах тухай санаачлага гаргаж болох бөгөөд нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцална.
 - 7.4.2. Даатгуулагч даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдлын тухай бичгээр мэдээлэх үүргээ санаатайгаар биелүүлээгүй бол даатгагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлаж болно.
- 7.4. Даатгагчийн буруугаас гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд хохирол гараагүй бол үлдсэн хугацаанд ногдох хураамжийг буцаан олгоно, даатгуулагчийн буруугаар гэрээг цуцалбал

үлдсэн хугацаанд ноогдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Нөхөн төлбөр авсан, 9 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд буцаалт хийхгүй. Хураамжийг буцаан олгохдоо гэрээтэй холбогдох зардлыг хасаж олгоно.

- 7.5. Даатгуулагч иргэн бол эхнэр, нөхөр, хүүхдээ эсвэл хамтран даатгуулагчаа, даатгуулагч хуулийн этгээд бол хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажилладаг ажилтнаа хамтран даатгуулагчаар гэрээнд нэрийг нь бүртгүүлж болно.
- 7.6. Гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар эсвэл гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 7.7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 7.8. Гэрээг талууд нотариатаар батлуулах эсэх талаар тохиролцоно.
- 7.9. Гэрээг Монгол хэлээр хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 эх хувь үйлдэж талууд нэг нэг хувийг авч хадгална.

НАЙМ. ДААТГУУЛАГЧ, ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Даатгуулагчийн эрх, үүрэг:

- 8.1.1. Нөхөн төлбөрийг гэрээнд заасны дагуу даатгагчаас гаргуулан авах.
- 8.1.2. Даатгалын хууль, гэрээтэй холбоотой тайлбар, зөвлөгөө авах.
- 8.1.3. Даатгалын гэрээг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авах.
- 8.1.4. Даатгагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэрээг цуцлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах.
- 8.1.5. Даатгуулагч даатгалтай тээврийн хэрэгслийн улсын дугаар, хөдөлгүүрийн дугаар өөрчлөгдөх, өнгө солигдох зэргээр өөрчлөлт орсон тохиолдолд даатгагчид 14 хоногийн дотор мэдэгдэн даатгалын гэрээндээ өөрчлөлт оруулах эрх үүрэгтэй.
- 8.1.6. Даатгалтай тээврийн хэрэгслийн өмчлөлд өөрчлөлт орж шинэ өмчлөгчид шилжүүлсэн тохиолдолд даатгуулагч эсвэл шинэ өмчлөгч даатгагчид нэн даруй мэдэгдэн даатгалын гэрээгээ цуцлах, шинээр байгуулах асуудлаар саналаа ирүүлэх үүрэгтэй.
- 8.1.7. Даатгалтай тээврийн хэрэгсэлд байрлуулсан нэмэлт тоног төхөөрөмжийн талаар даатгалын гэрээ байгуулах үедээ даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.
- 8.1.8. Даатгалтай холбоотой баримт, мэдээллийг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.
- 8.1.9. Тээврийн хэрэгслийг зах зээлийн үнээр, хариуцлагын даатгалд тогтоосон хязгаараас доошгүй үнэлгээгээр даатгуулах.
- 8.1.10. Даатгалын зүйлийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдлын үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой бүхий л арга хэмжээг авах.
- 8.1.11. Даатгалын тохиолдлын талаар даатгагчид Шуурхай албаны 24 цагийн үйлчилгээтэй 94034800, 99054800 утсуудаар, ажлын цагаар 319900 утсаар НЭН ДАРУЙ мэдэгдэж хүндэтгэх шалтгаангүй бол даатгалын ажилтан, замын цагдаа ирж үзтэл тээврийн хэрэгслийг ослын дараах байдлаар нь хадгалж ослын шалтгааныг тогтоолгох үүрэгтэй.

- 8.1.12. Даатгалын гэрээ байгуулах үеийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлүүд өөрчлөгдсөн тохиолдолд даатгагчид мэдэгдэх.
- 8.1.13. Даатгалын хууль, гэрээний дагуу даатгагчаас гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авахад даатгагчид бүх талын туслалцааг үзүүлэх.
- 8.1.14. Даатгалын тохиолдлын үед даатгалын гэрээнд заасан өөрийн хүлээх хариуцлагын хэмжээгээр үүрэг хүлээх.
- 8.1.15. Даатгал хийлгэхтэй болон нөхөн төлбөр гаргуулан авахтай холбоотой баримт, материалыг даатгагчид саадгүй, үнэн зөв гаргаж өгөх;

8.2. Даатгуулагчийн тусгай үүрэг:

- 8.2.1. Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, Монгол улсын зам тээврийн хөдөлгөөнд оролцох эрх олгох үзлэгт орсон байх
- 8.2.2. Монгол улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм журмыг ёсчлон биелүүлж хөдөлгөөнд оролцох Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах.
- 8.2.3. Даатгалын тохиолдол болсон үед бодит хохирлын хэмжээг үнэн зөв гаргаж өгөх
- 8.2.4. Үйлдвэрлэгчээс гаргасан техник ашиглалын заавар, ажиллагааны зааврыг зөрчихгүй байх
- 8.2.5. Тээврийн хэрэгслийн найдвартай байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн ашиглалтын горим, зааврыг зөрчилгүй, даац, ачаалал хэтрүүлэхгүй байх.

8.3. Даатгагчийн эрх, үүрэг:

- 8.3.1 Даатгуулагч хуурамч мэдээлэл өгсөн нь нотлогдвол түүнчлэн даатгалын хураамжийг хууль буюу гэрээгээр тогтоосон хугацаанд төлөөгүй бол гэрээг цуцлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардах.
- 8.3.2 Даатгалын тохиолдолын газар дээр очиж даатгалын гэрээнд заасан эрсдэл үүсэн эсэхийг нягталж тогтоох, учирсан хохирлын хэмжээг нэг бүрчлэн тогтоож даатгуулагчид танилцуулах.
- 8.3.3 Даатгуулагчид учирсан хохиролд зах зээлийн үнийн судалгаа хийсний үндсэн дээр үнэлгээ хийж даатгуулагчид танилцуулна.
- 8.3.4 Даатгуулагчаас ирүүлсэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авч шаардлагатай гэж үзвэл нэмэлт материал гаргуулан авах эрхтэй.
- 8.3.5 Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр болон түүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авах эрхийг шилжүүлэн авах.
- 8.3.6 Даатгуулагчийн ирүүлсэн даатгалын нөхөн төлбөр хүссэн баримт материал эргэлзээтэй тохиолдолд эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж дүгнэлт тодорхойлолт гаргуулах.
- 8.3.7 Даатгалын зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгах.
- 8.3.8 Шаардлагатай тохиолдолд жолоо барьж явсан хүнийг согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, шалгуулах.
- 8.3.9 Даатгалын тохиолдлын улмаас бүрэн сүйрсэн тээврийн хэрэгсэл болон эвдэрч гэмтсэн эд ангийг даатгагч шинээр сольж, нөхөн сэргээсэн бол тухайн тээврийн хэрэгсэл, гэмтсэн эд ангийг өөрийн мэдэлд авах эрхтэй.
- 8.3.10 Даатгалын нөхөн төлбөр хүссэн өргөдөл, материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан нөхөн төлбөрийг олгох.

- 8.3.11 Зам тээврийн осол хэрэг эрх бүхий Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагад шалгагдаж хянагдаж байгаа тохиолдолд даатгагч энэхүү гэрээний 8.3.10-д заасан хугацааг хойшлуулах эрхтэй.
- 8.3.12 Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд даатгуулагчийн талаар өөрт хадгалагдаж буй мэдээ материалын нууцыг задруулахгүй байх.
- 8.3.13 Даатгалын гэрээ байгуулах, үүссэн хохирлыг шуурхай чирэгдэлгүй барагдуулах үүднээс даатгуулагчид хууль тогтоомж, гэрээний нөхцлийн талаар үнэн зөв мэдээлэл, бүрдүүлэх баримтын асуудлаар зөвлөгөө өгнө.
- 8.3.14 Даатгалын эрсдлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг нөхөн төлбөр дээр нэмж тооцох.

ЕС. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ

- 9.1. Санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчныг бүрдүүлсэн Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 2,3 а-д заасан нөхцөлүүд.
- 9.2. Даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.
- 9.3. Даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд, түүний эрх ашгийг хамгаалагч гуравдагч этгээдийн санаатай үйлдлээс учирсан хохирол.
- 9.4. Тээврийн хэрэгслийг согтуугаар эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоодсон, хурд хэтрүүлсэн нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, гэмт хэргийн зорилгоор хууль бусаар ашиглах үед үүссэн хохирол.
- 9.5. Ослын талаар даатгагч болон Замын Цагдаагийн байгууллагад хүндэтгэх шалтгаантайгаас бусад тохиолдолд зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэж ослын шалтгааныг тогтоолгоогүй, эсвэл ослын шалтгааныг тогтоох боломжгүй болсон.
- 9.6. Гэрээнд заагдаагүй эрсдэлийн улмаас үүссэн хохирол.
- 9.7. Автомашины эвдрэл, цахилгааны гэмтэл, нэмэлт тоног төхөөрөмжийн гэмтэл, автомашинд хийсэн засварын ажлаас шалтгаалан гарсан гал болон эвдрэл зэргээр автомашинаас өөрөөс нь үүссэн галын хохирол.
- 9.8. Тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, тухайн ангилалын тээврийн хэрэслийг жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан үедээ автомашин жолоодсон, эрүүл мэндийн хувьд жолоо барих шаардлага хангахгүй этгээдээр жолоо бариулсан үед учирсан хохирол.
- 9.9. Тээврийн хэрэгслийг жолооны сургалтын зориулалтаар ашиглах, ан ав хөөх, уралдаан тэмцээнд оролцуулах, тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хязгаараас хэтрүүлэх, тээврийн хэрэгслийн хүч, туулах чадварыг турших, баталгаат бус замаар зорчих, гол ус гатлах зэргээс учирсан хохирол.
- 9.10. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн бол тэр хэмжээгээр.
- 9.11. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйн улмаас автомашинд гарсан ердийн эвдрэл, автомашины ашиглалтаас хамаарсан элэгдэл хорогдол, үйлдвэрийн гологдлоос учирсан хохирол.
- 9.12. Зам тээврийн ослоос үл хамаарах шалтгаанаар тээврийн хэрэгслээр хад чулуу, хатуу биет зүйл мөргөх зэргээр даатгалын тохиолдол бий болох орчин нөхцлийг даатгуулагч өөрийн буруугаас бүрдүүлснээс учирсан хохирол.
- 9.13. Монгол улсын Замын Хөдөлгөөний Дүрэмд заагдсан дор дурьдсан тохиолдолд үүссэн гэмтэл, хохирол:
 - 9.12.1. Тээврийн хэрэгслийг ашиглахыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хориглосон шийдвэр гаргасан, техникийн гэмтэлтэй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оруулснаас үүссэн хохирол.
 - 9.12.2. Зорчигч болон ачаа тээш тээвэрлэх журмыг зөрчсөнөөс үүссэн хохирол.
- 9.14. Даатгалын тохиолдолтой холбоогүй механик засвар үйлчилгээ, машины нөхцөл байдлыг сайжруулах болон тэдгээрийн үр дагавраас үүссэн хохирол.
- 9.15. Ослоос бусад шалтгаанаар электрон компьютер, компьютерын программ хангамжинд учирсан хохирол, мөн тэдгээрээс үүссэн аливаа хохирол.
- 9.16. Хулгай, дээрмийн улмаас даатгалтай машин дотор байсан хувийн эд зүйл, нэмэлт тоноглол, өөр даатгалд хамрагдсан эд хөрөнгө болон задгай бүхээгтэй машин доторх эд зүйл алдагдсанаас үүссэн хохирол.

- 9.17. Даатгуулагч гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн хохирол.
- 9.18. Гэрээнд тусгайлан заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах хохирол.
- 9.19. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл үүссэн.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1 Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр яриа хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.
- 10.2 Эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй нөхцөлд Монгол улсын Санхүүгийн зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлнэ. Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд Монгол улсын Шүүхэд гомдол гаргаж болно.
- 10.3 Хууль тогтоомжид өөрчлөлт орвол энэ журамд өөрчлөлт оруулна.
- 10.4 Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ, даатгалын нөхөн төлбөртэй холбогдон гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ юуны өмнө Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хуулийн заалтыг удирдлага болгоно.

АРВАН НЭГ. БУСАД

- 11.1 Энэхүү гэрээг Монгол хэлээр хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 эх хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалав.
- 11.2 Даатгагч нь даатгуулагчид тээврийн хэрэгсэл даатгагдсан тухай нотолгоо болгож даатгалын гэрээт баталгаа олгох бөгөөд энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Даатгагчийг төлөөлж:

Даатгуулагчийг төлөөлж:

.....

.....

Байгууллагын тээврийн хэрэгслийн даатгалын боломжит хураамжийн хувь

Хураамжийн хувь / Байгууллага						
ӨГӨГДӨЛ	НИЙТ ЗАХ ЗЭЭЛ 2014.И*	А АНГИЛАЛ	В АНГИЛАЛ	С АНГИЛАЛ	Д АНГИЛАЛ	М АНГИЛАЛ
С Гэрээний үнэлгээ	20,000,000	-	-	-	-	-
Tnc Нетто хувь	0.00517	-	-	-	-	-
N Цэвэр хураамж	103,388	-	-	-	-	-
Kd Гэрээний тоо	6,972	-	-	-	-	-
Kb Төхиолдлын тоо	2,262	-	-	-	-	-
P Төхиолдол илрэх магадлал	0.32444	-	-	-	-	-
Cc Үнэлгээний дундаж	20,000,000	-	-	-	-	-
Cb Нөхөн олговрын дундаж	300,000	-	-	-	-	-
K Засварлах илтгэцүүр	0.01500	-	-	-	-	-
T0 Нэмэгдэлгүй нетто хувь	0.004867	-	-	-	-	-
Tr Эрдэлийн нэмэгдэл хувь	0.00030	-	-	-	-	-
Tnc Нэмэгдэл нетто хувь	0.00517	-	-	-	-	-
Tbc Бруто хувь	-0.99700	-	-	-	-	-
H Нэмэгдэл хураамж	1.72313	-	-	-	-	-
PP Нийт хураамжийн хувь хэмжээ	1.72313	-	-	-	-	-

Хувь хүний тээврийн хэрэгслийн даатгалын боломжит хураамжийн хувь

Хураамжийн хувь / Хувь хүн						
ӨГӨГДӨЛ	НИЙТ ЗАХ ЗЭЭЛ 2014.И*	А АНГИЛАЛ	В АНГИЛАЛ	С АНГИЛАЛ	Д АНГИЛАЛ	М АНГИЛАЛ
С Гэрээний үнэлгээ	20,000,000	-	-	-	-	-
Tnc Нетто хувь	0.00609	-	-	-	-	-
N Цэвэр хураамж	121,707	-	-	-	-	-
Kd Гэрээний тоо	13,890	-	-	-	-	-
Kb Төхиолдлын тоо	5,428	-	-	-	-	-
P Төхиолдол илрэх магадлал	0.39078	-	-	-	-	-
Cc Үнэлгээний дундаж	20,000,000	-	-	-	-	-
Cb Нөхөн олговрын дундаж	300,000	-	-	-	-	-
K Засварлах илтгэцүүр	0.01500	-	-	-	-	-
T0 Нэмэгдэлгүй нетто хувь	0.005862	-	-	-	-	-

Тр	Эрсдэлийн нэмэгдэл хувь	0.00022	-	-	-	-	-
Тпс	Нэмэгдэл нетто хувь	0.00609	-	-	-	-	-
Тбс	Бруто хувь	-0.99700	-	-	-	-	-
		2.02844	-	-	-	-	-
Н	Нэмэгдэл хураамж	2.02236	-	-	-	-	-
PP	Нийт хураамжийн хувь хэмжээ	2.02844	-	-	-	-	-

Газарзүйн байршлаарх байгууллагын тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн хувь

Хураамжийн хувь / байгууллага			
ӨГӨГДӨЛ	УЛААНБААТАР/ ДАРХАН, ЭРДЭНЭТ/	ДОРНОД*	ХӨВСГӨЛ*
С	Гэрээний үнэлгээ	20,000,000	-
Тпс	Нетто хувь	0.00571	-
Н	Цэвэр хураамж	114,191	-
Кd	Гэрээний тоо	20,862	-
Кb	Тохиолдлын тоо	7,690	-
Р	Тохиолдол илрэх магадлал	0.36861	-
Сс	Үнэлгээний дундаж	20,000,000	-
Сb	Нөхөн олговорын дундаж	300,000	-
К	Засварлах илтгэцүүр	0.01500	-
Т0	Нэмэгдэлгүй нетто хувь	0.005529	-
Тр	Эрсдэлийн нэмэгдэл хувь	0.00018	-
Тпс	Нэмэгдэл нетто хувь	0.00571	-
Тбс	Бруто хувь	-0.99700	-
		1.90319	-
Н	Нэмэгдэл хураамж	1.89748	-
PP	Нийт хураамжийн хувь хэмжээ	1.90319	-

Газарзүйн байршлаарх хувь хүний тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн хувь

Хураамжийн хувь/ хувь хүн			
ӨГӨГДӨЛ	УЛААНБААТАР/ ДАРХАН, ЭРДЭНЭТ/	ДОРНОД*	ХӨВСГӨЛ*
С	Гэрээний үнэлгээ	20,000,000	-
Тпс	Нетто хувь	0.00609	-
Н	Цэвэр хураамж	121,707	-
Кd	Гэрээний тоо	13,890	-
Кb	Тохиолдлын тоо	5,428	-
Р	Тохиолдол илрэх магадлал	0.39078	-
Сс	Үнэлгээний дундаж	20,000,000	-

Сь	Нөхөн олговрын дундаж	300,000	-	-
К	Засварлах илтгэцүүр	0.01500	-	-
Т0	Нэмэгдэлгүй нетто хувь	0.005862	-	-
Тр	Эрсдэлийн нэмэгдэл хувь	0.00022	-	-
Тпс	Нэмэгдэл нетто хувь	0.00609	-	-
Тбс	Бруто хувь	-0.99700	-	-
		2.02844	-	-
Н	Нэмэгдэл хураамж	2.02236	-	-
РР	Нийт хураамжийн хувь хэмжээ	2.02844	-	-

ХЭСЭГ 12 ХАВСРАЛТУУД**Мэдүүлгийн маягт**

№	Үзүүлэлт	Мэдүүлэх хэсэг
1	Даатгуулагч/Овог нэр:	
2	Регистрийн дугаар:	
3	Даатгуулагчийн хаяг:	
4	Даатгуулагчийн утас:	
5	Жолоочийн үнэмлэхний дугаар:	
6	Тээврийн хэрэгслийн марк:	
7	Арлын дугаар:	
8	Үйлдвэрлэсэн он:	
9	Улсын дугаар:	
10	Даатгалын үнэлгээ	
11	Тээврийн хэрэгслийн ангилал	
12	Тээврийн хэрэгслийн ашиглах газар зүйн байршил	
13	Тээврийн хэрэгслийн насжилт	
14	Тээврийн хэрэгслийн зориулалт	<input type="checkbox"/> Хувь <input type="checkbox"/> Байгууллага
15	Нөхөн төлбөрийн түүх	
16	Тээврийн хэрэгслийн нөхцөл байдал	<input type="checkbox"/> Шинэ <input type="checkbox"/> хуучин
17	Тээврийн хэрэгслийн ашиглах нөхцөл	<input type="checkbox"/> Хүн тээвэр <input type="checkbox"/> Ачаа тээвэр <input type="checkbox"/> Түрээс <input type="checkbox"/> Хязгаарлагдмал талбайд
18	Даатгагчийг төлөөлж:	_____ /...../
19	Даатгуулагчийг төлөөлж:	_____ /...../
20	Мэдүүлсэн огноо :	

Нөхөн төлбөрийн маягт

№	Үзүүлэлт	Мэдүүлэх хэсэг
1	Даатгалын гэрээний дугаар:	
2	Даатгуулагч/Овог нэр:	
3	Регистрийн дугаар:	
4	Даатгуулагчийн хаяг:	
5	Даатгуулагчийн утас:	
6	Жолоочийн үнэмлэхний дугаар:	
7	Тээврийн хэрэгслийн марк:	
8	Арлын дугаар:	
9	Үйлдвэрлэсэн он:	
10	Улсын дугаар:	
11	Даатгалын үнэлгээ:	

12	Даатгалын эхлэх хугацаа	
13	Даатгалын дуусах хугацаа	
14	Даатгалын тохиолдол болсон хугацаа	
15	Авто осол болон хохирлын талаар Та дэлгэрэнгүй бичнэ үү:	
16	Та нөхөн төлбөрийг ямар хэлбэрээр хийгдэхийг хүсэж байна вэ?	<input type="checkbox"/> Банк-Дансны дугаар <input type="checkbox"/> Бэлнээр (мөнгөний нэгж)
17	ХЭРВЭЭ ТА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН БОЛ ДАРААХ ХҮСНЭГТИЙГ БӨГЛӨНӨ	17.1. Та ЗЦГ-г хандсан уу? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй 17.2. Та Цагдаагийн газар эсвэл Гал унтраах албанд хандсан уу? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй 17.3. Та мэргэжлийн үнэлгээний байгууллагад хандсан уу? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй 17.4. Хэрвээ ТИЙМ бол дараах мэдээллийг өгнө үү: Хандсан хугацаа: Огноо: жж / сс / өө Цаг: цц/мм
18	<p>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН АНХААРАЛД: Таны бүрдүүлж өгсөн нэхэмжлэл болон бусад материалууд хохирлыг нотлох шаардлагыг хангасан байх хэрэгтэй. Даатгалын тухай хуулийн 8.7-д зааснаар бид Таны хохирлыг нөхөн барагдуулах хугацаандаа буруутай этгээдээс төлбөрөө нэхэмжлэн авах эрхтэй ба Та бүхий л талын туслалцаа үзүүлж бидэнтэй хамтран ажиллах үүрэгтэй. Хэрвээ Та манай эрхийг ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд бид нөхөн олговрын дүнг олгохоос татгалзах эсвэл багасгасан хэмжээгээр нь хасах замаар энэ алдагдлаа нөхөж авах эрхтэй. Буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх Таны эрх нь энэ даатгалаар олгогдсон нөхөн олговор, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр бидэнд шилжинэ. Бид шаардлагатай гэж үзвэл ажлын цагаар нөхөн олговортой холбогдсон Таны нэхэмжлэл, баримтуудыг шалгах эрхтэй болно. Таны нэхэмжлэлийг шийдвэрлэхэд Та бидэнд ажлын 14 хоногийн хугацаа өгнө үү. Та бөглөсөн маягтаа доорх хаягаар илгээнэ үү.</p>	
19	<p>ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛЭГ: Би үнэн зөв мэдүүлснээ баталж байна. Би өөрийн нөхөн олговрын асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор авто осол болон хохиролтой холбоотой бүхий л мэдээллээр Практикал Даатгал Компанийг хангаж байх эрхийг холбогдох байгууллагын удирдлага, ажилтнууд болон гэрчид олгож байна.</p>	
20	Гарын үсэг: Огноо: жж / сс / өө	
21	Өргөдөл гаргагчийн нэр:	
22	Мэдүүлсэн огноо :	

Нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт

1. Даатгуулагчийн даатгалын нөхөн төлбөр хүссэн өргөдөл, албан бичиг.
2. Даатгалын гэрээ, баталгааны эх хувь.
3. Даатгалын тохиолдлын газар дээр ажилласан тухай протокол, дүгнэлт.
4. Даатгуулагч буруутай эсэхийг магадлах зорилгоор ослын шалтгааныг тогтоосон зам тээврийн ослын акт /акт үйлдэгдээгүй тохиолдолд тодорхойлолт.
5. Учирсан хохиролд үнэлгээ хийсэн эрх бүхий хохирол үнэлгээний компанийн дүгнэлт.

6. Эвдрэл гэмтэлд засвар хийсэн засварын газрын баримт.
7. Эвдрэл, гэмтлийн байдлыг харуулсан фото зураг.
8. Шаардлагатай тохиолдолд гал, үнэлгээ зэрэг мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагын дүгнэлт, тодорхойлолт.
9. Зам тээврийн осол хэрэг нь Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагад шалгагдаж, хянагдаж байгаа тохиолдолд тэдгээр байгууллагын шийдвэр.

Хохирлын үед авах арга хэмжээ:

Даатгалын тохиолдлын үед яаралтай авах арга хэмжээ:

- a. Авто тээврийн ослын үед даатгуулагч дараах арга хэмжээг нэн даруй авна:
 - Даатгагчид буюу Хохирлын Шуурхай Албанд нэн даруй мэдэгдэнэ
 - Холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх (замын цагдаа, гал түймэртэй тэмцэх алба болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд)
 - Хохирлыг багасгах бусад бүх үйл ажиллагааг авах
 - Даатгагчид хохирлын талаарх дараах баримт мэдээлэлийг явуулна:
 - Гарсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичгээр
 - Гэрчлэх баримт, бусад холбогдох материалыг
 - Шаардлагатай бол мэргэжлийн байгууллагын үнэлэлт, дүгнэлт
- b. Даатгалын нөхөн төлбөр олгох материал дутуу, хангалттай биш гэж үзсэн тохиолдолд даатгагч нөхөн төлбөр олгох хугацааг хойшлуулах эрхтэй
1. Гэмтэл бэртэлтэй холбоотой гэнэтийн ослын үед авах арга хэмжээ
 - a. Хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой нөхцөл байдлын үед шаардагдах түргэн тусламжийг яаралтай үзүүлэх
 - b. Түргэн тусламж, холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх
2. Даатгалын тохиолдол болсон газар боломжтой бол:
 - a. холбогдох баримт нотолгоо болох эд зүйлийг шинжлэн дүгнэх, шуурхай албаны хүмүүс иртэл хөндөхгүй, хэвээр байлгах;
 - b. түүнд оролцсон болон гэрчийн мэдүүлгийг үнэн зөвөөр авах;
 - c. тохиолдол болсон цаг хугацаа, газар, хэн бэртсэж гэмтсэн, нас барсан, ямар зүйл хохирсон талаар дэлгэрэнгүй мэдээлэл;
 - d. ямар ч хохирлын үед Шуурхай албанд нэн даруй яаралтай мэдэгдэж байх

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам актууд

1. ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Даатгалын ангилал, төрөл, хэлбэр
Гуравдугаар бүлэг	Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах
Дөрөвдүгээр бүлэг	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох
Тавдугаар бүлэг	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд..... тавих хяналт
Зургадугаар бүлэг	Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар
Долдугаар бүлэг	Нягтлан бодох бүртгэл, аудит
Наймдугаар бүлэг	Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан.....
Есдүгээр бүлэг	Давхар даатгал
Аравдугаар бүлэг	Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт
Арваннэгдүгээр бүлэг	Зах зээлийн ёс зүй
Арванхоёрдугаар бүлэг	Нэрэнд хяналт тавих
Арвангуравдугаар бүлэг	Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах
Арвандөрөвдүгээр бүлэг	Албадлага
Арвантавдугаар бүлэг	Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх
Арванзургадугаар бүлэг	Даатгагчийг татан буулгах
Арвандолдугаар бүлэг	Бусад

2. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг
	төрөөс зохицуулах
Гуравдугаар бүлэг	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны
	тусгай зөвшөөрлийн төрөл

Дөрөвдүгээр бүлэг	Хөрөнгө, хувьцаа
Тавдугаар бүлэг	Нягтлан бодох бүртгэл, аудит
Зургадугаар бүлэг	Даатгалын мэргэжлийн оролцогчид тавих хязгаарлалт
Долдугаар бүлэг	Зах зээлийн ёс зүй
Наймдугаар бүлэг	Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах
Есдүгээр бүлэг	Албадлага
Аравдугаар бүлэг	Бусад зүйл

3. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Даатгалын гэрээ
Гуравдугаар бүлэг	Даатгалын үнэлгээ, хураамж
Дөрөвдүгээр бүлэг	Даатгалын тохиолдол, нөхөн төлбөр
Тавдугаар бүлэг	Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт
Зургадугаар бүлэг	Мэдээллийн сан, шуурхай алба
Долдугаар бүлэг	Бусад

4. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ

(Хэсэгчлэн авав)

Дөчин гуравдугаар бүлэг	Даатгал
-------------------------	---------------

5. АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Автотээврийн талаархи төрийн байгууллагын
	бүрэн эрх

Гуравдугаар бүлэг	Тээвэрлэлт
Дөрөвдүгээр бүлэг стадартчилал	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэл,
Тавдугаар бүлэг	Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд
	хяналт тавих
Зургадугаар бүлэг	Бусад зүйл

6. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
Гуравдугаар бүлэг	Замын хөдөлгөөнд оролцогчид, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг
Дөрөвдүгээр бүлэг	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад орон нутгийн захиргаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны бүрэн эрх
Тавдугаар бүлэг	Бусад зүйл

7. МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ

1. Нийтлэг үндэслэл
2. Жолоочийн үүрэг
3. Явган зорчигчийн үүрэг
4. Тээврийн хэрэгслээр зорчигчийн үүрэг
5. Замын хөдөлгөөн зохицуулах дохио
6. Дуут болон ослын дохио, ослын зогсолтын тэмдэг хэрэглэх
7. Хөдөлгөөн эхлэх болон чиг өөрчлөх
8. Тээврийн хэрэгсэл байрлан явах
9. Тээврийн хэрэгслийн хурд

ХЭСЭГ 13 СТАТИСТИК МЭДЭЭ

- СЗХ-ны нэгтгэсэн статистик мэдээллүүд / даатгалын үнэлгээ, хураамжийн орлого, нөхөн төлбөрийн дүн /
- Даатгалын компаниудын статистик мэдээллүүд
- Статистикийн эмхэтгэлүүд /2010-2013 он/